



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/122

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ховд” нисэх буудалд зориулан шинээр зохиогдсон үзүүлэлтэд тулгуурласан навигацийн SID нислэгийн журмын шалгалтын нислэгийг гүйцэтгэх агаарын хөлөг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:

Г.Мөнгөнхуяг

Агаарын навигацийн үйлчилгээний газрын дэд дарга

Нарийн бичгийн дарга:

Г.Бат-Алдар

Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн

Гишүүд:

М.Байгал

Нислэгийн журам боловсруулалтын албаны дарга

А.Амарболд

Иргэний нисэхийн залуучуудын холбооны гишүүн

А.Энхцэцэг

“Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл” Төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Г.Мөнгөнхуяг)-нд үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Г.Бат-Алдар)-д даалгасугай.

ДАРГА

П.МӨНХЖАРГАЛ



1721 01 0904